



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 05 сар 14 өдөр

Дугаар 8/03-А097/АА-ДАА-2025/06-7-шт-74

Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Арвин тэмүүлэл” ХХК-ийн гүйцэтгэсэн “Дархан сумын 8 дугаар багийн тохижилт”-ын ажлын гар бөмбөгийн талбайн 5,951,990.00 төгрөгийн төсөвт өртөгтэй шалны будаг ховхорч, шаардлага хангахгүй болсон байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханганд нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна”, Техник хяналтын талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд хийсэн гэрээний 2.8-д “Чанаргүй буюу дутуу гүйцэтгэсэн зөрчил, дутагдалтай барилгын ажлын талаар дүгнэлт гаргах, тогтоосон хугацаанд засуулах, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээг авах”, 3.5-д “Буруу буюу дутуу ажлыг тогтоосон хугацаанд нь гүйцээлгэж, ажлын явцад илэрсэн дутагдал, зөрчил, догоолдлыг шуурхай арилгах”, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 6.3, гэрээний ерөнхий нөхцөлийн 6.14-т “Чанарын баталгаат хугацаа 2 жил байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэсгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

- Шаардлага хангаагүй 5,951,990.00 /Таван сая есөн зуун тавин нэгэн мянга есөн зуун ерэн/ төгрөгийн дээрх ажлыг чанартай гүйцэтгүүлж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ДХББЗГ ОНӨААТҮГ-ын дарга Д.Батбаяр, ахлах инженер У.Заяахүү нарт даалгав.

АЛБАНШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Х.СУВДМАА

АУДИТОР

Э.ОДГЭРЭЛ

БАТАЛГААЖУУЛСАН:

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МОНХБАЯР

Б.Оюун Имнэлжүүлж
4525040320